



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 22 өдөр

Дугаар А/239

Мөрөн сум

Дэд хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 18 зүйлийн 18.2, Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах дэд хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга

Я.Эрхэмбаяр (Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Б.Оюунтуяа (Аймгийн Засаг Даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Б.Батболд (Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга)

У.Адъяаням (Тогоочдын холбооны удирдах зөвлөлийн гишүүн)

Ч.Эрдэнэчимэг (Жимс, жимсгэний холбооны тэргүүн)


Ж.Сарангэрэл (Худалдаа аж үйлдвэрийн танхимын дарга)

Ц.Оюунцэцэг (Хөх ус нуур ТББ-ын тэргүүн)

Нарийн бичгийн дарга: (Б.Лхагвадулам (Жижиг дунд үйлдвэр, хөнгөн, хоршоо ахуйн үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн)

2. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журмыг мөрдөж ажиллах, төслийн мэдээллийг иргэд олон нийтэд мэдээллийн хэрэгслээр мэдээлж байхыг дэд хорооны дарга (Я.Эрхэмбаяр) –т үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАНТ